# Тавигдах шаардлага

Доорхи шаардлагыг хангасан байх.

1. Өөрийн улсдаа 12-с дээш жилийн болон түүнтэй дүйх боловсрол эзэмшсэн байх.
2. Доорхи A,B,C-н нөхцөлийг 1-с дээшийг хангасан байх.
   A. Япон хэлний түвшин тогтоох шалгалтны N1 эсвэл N2-т тэнцсэн байх.
   B. Японы сургуульд элсэх шалгалт（EJU）-ын Япон хэлний шалгалтын оноо 200-аас дээш авсан байх.
   C. Хууль зүйн сайдын баталсан япон хэлний боловсрол олгох байгууллагад 6-с дээш сар япон хэл сурсан байх.
3. Японд байх хугацаандаа сургалтын төлбөр болон амьдрах зардалыг төлж чадах эсэхийг батлах бичиг баримтыг бэлдэх.

# <u>Сургуульд элсэх бичиг баримт</u>

**Доор бичигдсэн 1-19 дугаар бүхий материалыг тус сургуулийн дугтуйнд хийж сургуульд ирүүлэх.**

※Бүх бичиг баримтын хуулга зэргийг A4 хэмжээгээр нэг талд хэвлэсэн байх.

| | Бүрдүүлэх бичиг баримт | Анхаарах зүйл | Оюутны визтэй бол | Ү/а-ны тусгай визтэй бол | Гэр бүлийн визтэй бол |
|---|---|---|---|---|---|
| 1. | Элсэлтийн өргөдөл | Элсэлтийн өргөдөл① болон элсэлтийн өргөдөл② гэсэн сургуулийн маягт ※2хуудас | ○ | ○ | ○ |
| 2. | Хариуцсан багшийн бичих хуудас | Багш хариулж чадах зүйлээ л бичих（зөвхөн суралцаж буй хүнд хамаарна） | ○ | × | × |
| 3. | Зохион бичлэгийн хуудас | Сэдвээ сонгоод бичих | ○ | ○ | ○ |
| 4. | Элсэлтийн шалгалт өгөх хуудас（Танхимаар эсвэл онлайнаар аль нэгийг сонгох） | Нүүрэн талын тод хүрээн доторхыг бичнэ үү | ○ | ○ | ○ |
| 5. | Я/хэлний сургуулийн дүн болон ирцийн тодорхойлолт | Дүн болон ирц（ирц нь цагаар）бичигдсэн байх ба дугтуйг битүүмжилсэн байх | ○ | ○ | △ |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 6. | Я/хэлний сургууль төгссөн（төгсөх）тодорхойлолт | Японд ирээд сурч байсан япон хэлний сургуулиас авах | ○ | ○ | △ |
| 7. | Коллеж болон их сургууль зэрэг сургуулийн дүн болон ирцийн тодорхойлолт | Дүн болон ирц бичигдсэн ба дугтуйг битүүмжилсэн байх | △ | △ | △ |
| 8. | Коллеж болон их сургууль зэрэг сургууль төгссөн тодорхойлолт（Япон） | Японд ирээд өдийг хүртэл сурч байсан сургуулиас авах. ※коллеж болон их сургуульд сурж байгаа бол төгссөн япон хэлний сургууль болон одоогийн сургуулийн аль алийг нь авах | △ | △ | △ |
| 9. | Өөрийн улсдаа 12-с дээш жилийн боловсрол эзэмшсэн бичиг | Япон хэл эсвэл англи хэлний орчуулгыг хавсаргах | × | × | ○ |
| 10. | Оршин суух үнэмлэхийн хуулбар（A4 хэмжээтэй,нэг талд хэвлэх） | Оршин суух үнэмлэхийн ар өвөр 2 тал. Үнэмлэхийн дугаар нь тод гарсан байх | ○ | ○ | ○ |
| 11. | Гадаад паспортны хуулбар（A4 цаасанд ,нэг талд хэвлэх） | Нүүрэн хуудас болон виз,хил гаалиар нэвтэрсэн бичилттэй бүх хуудсыг хэвлэх. | ○ | ○ | ○ |
| 12. | Батлан даагчийн бичиг | Япон хэлний сургуульд байгаа бичгийн хуулбар байж болно.<br>※Япон хэл эсвэл англи хэл дээрх орчуулгыг хавсаргах<br>※Хэрвээ байхгүй бол сургуулийн HP-с татаж аваад бичиж болно（Батлан даагч нь өөрөө бичих） | ○ | ○ | ○ |
| 13. | Мөнгө шилжүүлсэн баримтын хуулбар (хэрвээ байгаа бол) | Батлан даагчаас оюутанд өөрт нь мөнгө шилжүүлсэн гэдгийг батлах зүйл<br>※Япон хэл эсвэл англи хэл дээрх орчуулгыг хавсаргах | ○ | ○ | × |
| 14. | Банкны дэвтрийн хуулбар | Элсэгчийн өөрийн дэвтэр байх | ○ | ○ | △ |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | （A4 цаасанд ,нэг талд хэвлэх） | хэрэгтэй бөгөөд,сургалтын төлбөр болон амьдрах зардал зэрэг орлого зарлага бичигдсэн бүх хуудсыг хэвлэх. ( бичигдээгүй орхигдсон сарыг тухайн банканд хандан гаргуулж авах) | | | |
| 15. | Япон хэлний түвшинг батлах бичгийн хуулбар | JLPT N3-с дээш тэнцсэн, EJU 220-с дээш оноо авсан тохиолдолд л хуулбарыг бэлдэх | △ | △ | △ |
| 16. | Хамгийн сүүлд төлсөн татварын тодорхойлолт | Өмнөх жилийн цалингийн орлого бичигдсэн байх | ○ | ○ | × |
| 17. | Цээж зураг 1ш (3 сар доторхи) | 4×3 хэмжээтэй өнгөт зураг ар талд нь нэр, улс, төрсөн он сар өдрийг бичих（Сургуульд элсэх өргөдөлд наах） | ○ | ○ | ○ |
| 18. | Тусгай зөвшөөрөлтэй сургуулийн тодорхойлолт (элсэгч нь тусгай зөвшөөрөлтэй сургуулиас тодорхойлогдсон тохиолдолд) | | △ | × | × |
| 19. | Шалгалтын хураамж | 20,000иэн. Тус сургуулийн данс руу шилжүүлсэн баримтыг элсэлтийн өргөдөл①-н ар талд наах.ATM-д төлсөн тохиолдолд ч адил,наах. | ○ | ○ | ○ |

○заавал бэлдэх　　　△хамаарагдах хүн　　　×шаардлагагүй

5-8 нь харъяалагдаж байгаа болон төгссөн сургуулиасаа бэлдэх.

Бэлдэх материалд ойлгомжгүй зүйл байвал элсэлтийн алба руу холбогдоорой.

※Бүрдүүлсэн бичиг баримтыг бүртгэх жагсаалт: Бичиг баримтаа бүгдийг нь бүрдүүлсний дараа дугтуйны ард байгаа хүснэгтэнд ○ тэмдэглэгээ хийх.

※Сургуулийн зүгээс дээрх жагсаалтанд бичигдээгүй бичиг баримтыг нэмж шаардах тохиолдол байдаг.

※Элсэх өргөдөлөө өгсөний дараа JLPT болон EJU-д тэнцсэн тохиолдолд яаралтай холбогдох материалыг өгөх. Дэлгэрэнгүйг (төлбөр хөнгөлөх систем) –с харна уу.

Анхаарах зүйлс ・「Элсэх өргөдөл」 тус сургуулийн маягтыг ашиглах. (хэвлэж болно)

- Бичиг баримт дутуу тохиолдолд хүлээж авахгүй.
- Бичиг баримтыг хуурамчаар бүрдүүлсэн тохиолдолд элсэн орох зөвшөөрлийг цуцлана.
- Нэгэнт хүлээлгэн өгсөн бичиг баримтыг буцаахгүй болохыг анхаарна уу.
- Бүхий л бичиг баримтыг A4 хэмжээтэйгээр нэг талд хэвлэнэ үү.

Хэрхэн өргөдөл гаргах тухай

- Шуудангаар илгээх бол:※материал хүлээж авах өдөрт амжих
- Биеэр авч ирэх бол: 9:00-16:00 (ажлын өдөр даваа- баасан)

  Хаяг: Chiba-shi Wakaba-ku Nishitsuga 3-3-2

# Сургуульд элсэх өргөдөл гаргах хугацаа

2022 оны 8-р сарын 1 (Даваа) ~2023 оны 3-р сарын 6 (Даваа)

# Элсэлт явагдах хугацаа

| | 1-р | 2-р | 3-р | 4-р | 5-р | 6-р | 7-р | 8-р | 9-р | 10-р |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Өргөдөл хүлээн авах сүүлийн өдөр | 8 сарын 25 (Пүрэв) | 9 сарын 8 (Пүрэв) | 9 сарын 21 (Лхагва) | 10 сарын 6 (Пүрэв) | 10 сарын 20 (Пүрэв) | 11 сарын 2 (Лхагва) | 11 сарын 17 (Пүрэв) | 12 сарын 1 (Пүрэв) | 1 сарын 10 (мягмар) | 1 сарын 1 (Пүрэв) |
| Шалгалт авах өдөр | 9 сарын 9 (Баасан) | 9 сарын 22 (Пүрэв) | 10 сарын 7 (Баасан) | 10 сарын 21 (Баасан) | 11 сарын 4 (Баасан) | 11 сарын 18 (Баасан) | 12 сарын 2 (Баасан) | 12 сарын 16 (Баасан) | 1 сарын 20 (Баасан) | 2 сарын (Баасан |
| Шалгалтын хариу гарах өдөр (WEB) | 9 сарын 14 (Лхагва) | 9 сарын 28 (Лхагва) | 10 сарын 12 (Лхагва) | 10 сарын 26 (Лхагва) | 11 сарын 9 (Лхагва) | 11 сарын 24 (Пүрэв) | 12 сарын 7 (Лхагва) | 12 сарын 21 (Лхагва) | 1 сарын 25 (Лхагва) | 2 сарын (Лхагва |

※Шалгалтыг хэдэн ч удаа өгч болно. Бүртгэлийн тоо гүйцэхээр бүртгэлээ хаана.

# Элсэлтийн шалгалт авах хэлбэр

## （Шалгалт өгөх хэлбэрээ сонгоно уу）

・Сургуульд ирж шалгалт өгөх（Chiba Mode бизнес коллежид явагдана.）

・Онлайнаар өгөх（Zoom-р явагдана.）

※Элсэлтийн шалгалтын агуулга ижил.

※Онлайнаар өгөх хүмүүст:

① Сургуульд элсэх өргөдөлд бичсэн E-mail хаяг руу Zoom ID,нууц үгийг илгээнэ.

② Онлайн шалгалтыг интернет сүлжээ сайтай,нам гүм орчиныг бүрдүүлж ганцаараа өгнө.

③ Шалгалт өгөхийн өмнө компютер,таблет,гар утсандаа Zoom аппликэшн татаж шалгалтын бэлтгэл хангахыг анхааруулъя.

# Элсүүлэх арга, дараалал

① **Бичиг баримтын бүрдүүлэлтийг шалгах**

② **Зохион бичлэг**

③　**Япон хэлний ТТШ**

④　**Ярилцлага**

※Шалгаруулах арга, шалгалтын дүнгийн талаарх аливаа асуулт тодруулгыг хүлээж авахгүй болно.

# Төлбөр

| Сургалтын төлбөрийн задаргаа | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **1-р анги** | **Элсэлтийн хураамж** | **Халамжийн зардал** | **Сургуулийн танхим, т.төхөөрөмжийн зардал** | **Сургалтын нэмэлт зардал** | **Сурах бичгийн зардал** | **Хичээлийн төлбөр** | **Нийт** |
| | **100,000иэн** | **27,000иэн** | **100,000иэн** | **50,000иэн** | **50,000иэн** | **480,000иэн** | **807,00иэн** |
| **2-р анги** | **Элсэлтийн хураамж** | **Халамжийн зардал** | **Сургуулийн танхим, т.төхөөрөмжийн зардал** | **Сургалтын нэмэлт зардал** | **Сурах бичгийн зардал** | **Хичээлийн төлбөр** | **Нийт** |
| | **-** | **27,000иэн** | **100,000иэн** | **50,000иэн** | **50,000иэн** | **480,000иэн** | **707,000иэн** |

※Журмын хувьд төлбөрийг бөөнд нь хийнэ. Төлбөрийн хөнгөлөлтөнд хамрагдах оюутны хувьд төлбөр хуваах төлөх зааврыг дараах хэсгээс үзнэ үү.

※Сурах бичгийн зардалд сурах бичгийн үнэ,сургалтын материалын үнэ багтах бөгөөд шалгалтын төлбөр ороогүй болно.

※Түгээлтийн бизнесийн анги нь дээрхи төлбөрөөс гадна (сэрээт өргөгч По машины жолооны үнэмлэх, энгийн машины жолооны үнэмлэх, дунд оврын машины үнэмлэх зэргийг авах зардал) төлбөр хэрэгтэй болно.

※Төлбөр төлсний дараа буцааж авах боломжгүй.

# Сургуульд элсэх өргөдөл гаргаснаас элсэх хүртэл

1. Шалгалтын өдрийг мэдээлэх: Шалгалтаас 1 долоо хоногийн өмнө сурч буй сургуульд шуудангаар илгээх учир лавлаж тодруулж

   байх. Хэдийн төгссөн оюутан бол гэрийн хаягаар

илгээнэ.

2. Шалгаруулалт: ①Бичиг баримтын бүрдүүлэлтийг шалгах ②Зохион бичлэг ③Япон хэлний ТТШ ④Ярилцлага
3. Шалгалтын дүн: Элсэлтйин шалгалтын дараа сургуулийн Homepage-д дүнг танилцуулна. ※тэнцсэн оюутнуудад тэнцсэн бичиг болон элсэлтийн журмыг шуудангаар явуулна.
4. Сургалтын төлбөр төлөх: Шалгалтанд тэнцсэн хариу хүлээж аваад заасан хугацаанд зохих төлбөрийг төлж,сургуульд элсэх бичиг баримтыг бүрдүүлэх. ※заасан хугацаанд төлбөрийг төлөөгүй тохиолдолд элсэлтийг цуцлах тохиолдол байдаг.
5. Ирцийн тодорхойлолтыг дахин гаргах: 1-р сарын сүүлээр "Ирцийн тодорхойлолтыг дахин гаргах хүсэлт"-ийг сурч буй сургуульд явуулна. Заасан бичиг баримтыг бүрдүүлж явуулах.
6. Сургуульд элсэх зөвшөөрөл гардах: Төлбөрийг 2 дахиа хувааж төлсөний дараа болон ирцийн тодорхойлолтыг дахин гаргасаны дараа 2-р сараас хойш явуулна.
7. Сургуульд сурах удирдамж хүлээж авах: 4-р сард сургуульд элсэх эрх авсаны дараа сургуульд сурах удирдамж хүлээж авна.
8. Сургуульд элсэх ёслол: Танилцуулгыг сайтар уншсаны үндсэн дээр, цагийг чанд баримтлан ёслолын танхимд очих.

※Сургуульд сурах удирдамж болон Сургуульд элсэх ёслолын талаарх тайлбарыг "Сургуульд элсэх зөвшөөрөл"-тэй хамт илгээх болно.

# Төлбөр хөнгөлөх систем

## “Тусгай хөнгөлөлт A”

## Тодорхой нөхцөл хангасан тохиолдолд үзүүлэх хөнгөлөлт

① Элсэх хүсэлт гаргах үеийн ирц 95%-иас дээш, Япон хэлний ТТШ-ын N3 түвшинд тэнцсэн бол (Хоёуланг нь хангасан бол)....................................................672,000 иен

② Элсэх хүсэлт гаргах үеийн ирц 95%-иас дээш, эсвэл Япон хэлний ТТШ-ын N3түвшинд тэнцсэн бол. (Аль нэгийг нь хангасан бол)................................................702,000 иен

③ Элсэх хүсэлт гаргах үеийн ирц 90%-иас дээш бол.......................................732,000 иен

※Ирцийн тодорхойлолтыг дахин гаргах үе（1-р сарын сүүл）ийн ирц,элсэх хүсэлт гаргах үеийн ирцээс тодорхой шалтгаангүйгээр буурсан тохиолдолд,сургуульд элсэх эрхийг цуцлах,мөн тусгай хөнгөлөлтийн нөхцөл ч өөрчлөгдөх учир төлбөрийн хэмжээ ч өөрчлөгдөнө.

## “Тусгай хөнгөлөлт B”

## Япон хэлний түвшнээс шалтгаалан үзүүлэх хөнгөлөлт

① Япон хэлний ТТШ-ын N1 түвшинд тэнцсэн, эсвэл Японы сургуульд элсэх шалгалт（EJU）-ын Япон хэлний шалгалтын оноо 280-аас дээш бол（Бичгийн шалгалт хамаарахгүй）.......................................................................................552,000 иен

② Япон хэлний ТТШ-ын N2 түвшинд тэнцсэн бол,мөн Японы сургуульд элсэх шалгалт（EJU）-ын Япон хэлний шалгалтын оноо 220-аас дээш бол（Бичгийн шалгалт хамаарахгүй）.......................................................................................597,000 иен

※Элсэх хүсэлт гаргаснаас сургуульд орох хүртэл, “Тусгай хөнгөлөлт A ① ②・Тусгай хөнгөлөлт B”нөхцлийг хангасан хүний хувьд “Япон хэлний түвшнээс шалтгаалан үзүүлэх хөнгөлөлт”ийг эдлэх болно.

※Дээрх хөнгөлөлтөд хамрагдах хүн нь Япон хэлний ТТШ-нд тэнцсэн батламжийн хуулбарыг элсэлтийн комисст шуудангаар илгээнэ үү.
2023оны 2-р сарын 20-с өмнө хүсэлт гаргасан бол 2-р сарын 28-нд төлөх төлбөрийг хөнгөлөлттэй төлөх ба,сургуульд элсэж орохоос өмнө хүсэлт гаргасан бол 6-р сарын 30-нд

төлөх төлбөрийг хөнгөлөлттэй төлөх болно.

## “Энгийн элсэгчид A”

Элсэх хүсэлт гаргах үеийн ирц 85%-иас 90% бол төлбөрийг хуваaж төлөх боломжтой...................................................................................................................807,000 иен

※Ирцийн тодорхойлолтыг дахин гаргах үе（1-р сарын сүүл）ийн ирц,элсэх хүсэлт гаргах үеийн ирцээс тодорхой шалтгаангүйгээр буурсан тохиолдолд,сургуульд элсэх эрхийг цуцлах,мөн төлбөр хуваaж төлөх боломжгүй болно.

※Төгссөн оюутан ч мөн тодорхой нөхцөлөөс хамааран төгссөн сургуулийнхаа ирцнээс хамаараад төлбөрийн хөнгөлөлтөнд хамрагдана.

## “Энгийн элсэгчид B”

“Тусгай хөнгөлөлт A” , “Тусгай хөнгөлөлт B” , “ Энгийн элсэгчид A” –д хамрагдах боломжгүй бол төлбөрийг бөөнд нь 1 удаа төлөх..............................................................................807,000 иен

# Төлбөр хуваaж төлөх байдал

**Олон улсын бизнесийн анги （4 хуваaж төлөх）**

| | Төлөх өдөр | “Тусгай хөнгөлөлт A” ① | “Тусгай хөнгөлөлт A” ② | “Тусгай хөнгөлөлт A” ③ | “Тусгай хөнгөлөлт B” ① | “Тусгай хөнгөлөлт B” ② | “Энгийн элсэгчид A” |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 анги | Тэнцсэн үед | 150,000 | 150,000 | 150,000 | 150,000 | 150,000 | 200,000 |
| | 2023.02.28 | 222,000 | 252,000 | 282,000 | 102,000 | 147,000 | 307,000 |
| | 2023.06.30 | 150,000 | 150,000 | 150,000 | 150,000 | 150,000 | 150,000 |
| | 2023.09.29 | 150,000 | 150,000 | 150,000 | 150,000 | 150,000 | 150,000 |
| | **Нийт** | **672,000** | **702,000** | **732,000** | **552,000** | **597,000** | **807,000** |
| 2 анги | 2024.02.29 | 207,000 | 207,000 | 207,000 | 207,000 | 207,000 | 207,000 |
| | 2024.04.30 | 150,000 | 150,000 | 150,000 | 150,000 | 150,000 | 150,000 |
| | 2024.06.28 | 100,000 | 100,000 | 100,000 | 100,000 | 100,000 | 100,000 |
| | 2024.09.30 | 250,000 | 250,000 | 250,000 | 250,000 | 250,000 | 250,000 |
| | **Нийт** | **707,000** | **707,000** | **707,000** | **707,000** | **707,000** | **707,000** |

※Бусад үйл ажиллагааны зардал нь тусдаа бодогдоно.